

Жор баригчийн мэргэжлийн ёс зүйн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь

Б.Удвал¹, Б.Мягмарсүрэн¹, С.Мөнхбат¹

¹АШУҮИС, Эм зүйн сургууль, Эмнэлзүйн эм зүй, менежментийн тэнхим
Цахим иуудан: Udva5555@gmail.com, Утас: 88074187

Түлхүүр үг:

Эм зүйн
мэргэжилтэний
ёс зүй
Нийтийн
үйлчилгээтэй
эмийн сан
Эм зүйч
Эрүүл мэндийн
мэргэжилтэн

Товч утга:

Үндэслэл: Эмийн санд ажиллаж буй эм зүйн мэргэжилтнүүд бол нийтэд хамгийн хүртээмжтэй эрүүл мэндийн мэргэжилтэн бөгөөд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгуур юм. Тэд өөрийн бие даасан байдал, байгууллагын зорилго, мэргэжлийн үйл ажиллагааны стандартын тэнцвэрийг хадгалж ажиллах шаардлагатай бөгөөд ёс зүйн олон бэрхшээл, сорилттой тулгардаг болохыг цөөнгүй судалгаанд онцлон тэмдэглэсэн байна. Олон улсад нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа эм зүйн мэргэжилтнүүдийн анагаах ухааны ёс зүйн мэдлэг, үүсэж буй ёс зүйн асуудалд хандах хандлага, түгээмэл тохиолдож буй асуудлыг илрүүлэх судалгаа нэлээдгүй хийгдсэн ч манай улсад энэ чиглэлээр хийсэн судалгаа ховор байгаа нь уг судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн мэргэжлийн ёс зүйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх. **Арга, аргачлал:** Энэхүү судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загварыг ашиглан 2024 оны 03 сараас 09 сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн санд 3 сараас дээш хугацаанд ажиллаж байгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 374 жор баригчийг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулав. Судалгааны мэдээллийг 4 бүлэг, 39 хаалттай асуулт бүхий асуумжаар цуглуулан мэдлэг, хандлага, дадлын түвшнийг тодорхойлов. Статистик боловсруулалтад SPSS-25.0 программ ашигласан. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдын 339 (90.4%) нь эмэгтэй ба 301 (80.48%) нь эм зүйч, 73 (19.52%) эм найруулагч байв. Мөн 259 (69.3%) нь II зэрэглэлийн эмийн санд ажилладаг бөгөөд ёс зүйн сургалтад 305 (81.6%) нь хамрагдсан. Эм зүйн мэргэжилтнүүдийн 56.1% нь мэргэжлийн ёс зүйн дүрмийн мэдлэг хангалтгүй, 54.5% нь ёс зүйн асуудалд хандах хандлага муу, 48.9% нь зохисгүй дадалтай байгаа нь тогтоогдсон бөгөөд мэргэжилтэй нь уялдуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаагүй байв. Жор баригчдын ёс зүйн мэдлэг нь мэргэжил, нас, нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилласан жил, мэргэжлийн зэрэг, төгссөн сургууль зэрэгт ялгаагүй, харин оролцогчдын өөрийгөө үнэлсэн ёс зүйн мэдлэгийн үнэлгээтэй статистик ач холбогдол бүхий хамааралтай байна (CL 95%, $p=0.0001$). **Дүгнэлт:** 1. Жор баригч нарын мэргэжлийн ёс зүйн зарчим, хэм хэмжээний талаарх мэдлэг хангалтгүй байна. 2. Ёс зүйн зарим тохиолдлуудад хандах хандлага сөрөг, дадал зохисгүй байна. Иймд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг талаарх мэдлэг олгох сургалтыг эм зүйн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд суурилан эрчимжүүлэх шаардлагатай юм.

Үндэслэл: Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь иргэдэд урьдчилан цаг товлох, төлбөр төлөхгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг олгодог эрүүл мэндийн байгууллага юм.¹ ДЭМБ

болон Олон улсын эм зүйн холбооноос (FIP) эмийн сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго бол нийтийн эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулах, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмийн үр нөлөөг хамгийн

сайн байлгахад туслах явдал юм хэмээн тодорхойлсон бөгөөд сүүлийн жилүүдэд эмийн сан нь бүтээгдэхүүнд суурилсан загвараас үйлчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх төв болон өөрчлөгдөж байна.^{2,3}

Нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж буй эм зүйчид бол хамгийн хүртээмжтэй эрүүл мэндийн мэргэжилтнүүд бөгөөд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгуур гэж тэмдэглэсэн байна.⁴ Эрүүл мэндийн мэргэжилтэн байх нь эмийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг баримтлахыг шаарддаг.⁵ Дэлхий даяар жор баригч нарын мэдлэг, үүрэг технологийн дэвшилттэй зэрэгцэн эм, эмнэлгийн хэрэгслийг хангах, олгохоос эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлд шилжиж эхэлснээр эмийн эмчилгээний менежмент (MTM)-ийг хэрэгжүүлэх, чихрийн шижин, цусны даралт ихсэлт, дислипидеми, астма, тамхидалт зэрэг архаг явцтай өвчнүүдийн үед эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх зэрэг үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа нь өдөр тутам ёс зүйн асуудалтай тулгарах нөхцөлийг бүрдүүлж байна.^{6,7}

Эмийн сангийн орчинд ёс зүйтэй шийдвэр гарган ажиллахын тулд жор баригч нар өөрийн бие даасан байдал, байгууллагын зорилго, мэргэжлийн үйл ажиллагааны стандартын тэнцвэрийг хадгалж ажиллах шаардлагатай болдог нь ёс зүйн хувьд сорилттод оруулдаг. Мөн эмийн нэр төрөл нэмэгдэх, зөвхөн жороор олгох эмийн зохицуулалт алдагдах, эмийн зах зээл либералчлагдаж эмийн сангууд бизнесийн байгууллага болсноор жор баригчийн ажил арилжааны хэлбэрт шилжих, өөрсдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд идэвхтэй оролцох үйлчлүүлэгчийн тоо болон жирэмслэлтээс хамгаалах дааврын бэлдмэл зэрэг ёс зүйн хувьд эмзэг эмийн хүртээмж нэмэгдэх зэрэг нь ёс зүйн шинэ сорилтуудыг бий болгосоор байна.⁸

Олон улсад нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажиллаж байгаа эм зүйн мэргэжилтнүүдийн анагаах ухааны ёс зүйн мэдлэг, үүсэж буй ёс зүйн асуудалд хандах хандлага, түгээмэл тохиолдож буй асуудлыг илрүүлэх судалгаа нэлээдгүй хийгдсэн ч манай улсад энэ чиглэлээр хийсэн судалгаа ховор байгаа нь уг

судалгааг хийх үндэслэл боллоо.


Зорилго: Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригчийн мэргэжлийн ёс зүйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх.

Зорилт:

1. Жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёс зүйн тулгуур зарчим, ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдлэгийг үнэлэх
2. Жор баригч нарын зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага, дадлыг тодорхойлох.

Арга, аргачлал: Энэхүү судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загварыг ашиглан АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 01 сарын 19-ний өдрийн зөвшөөрлийн (2024/3-01) дагуу Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээтэй эмийн санд 3 сараас дээш хугацаанд ажиллаж байгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 374 жор баригчийг санамсаргүй түүврийн аргаар сонгож хамруулав. Судалгааны мэдээллийг 4 бүлэг, хаалттай 39 асуулт бүхий асуумжийн хуудсаар цуглуулав. Асуумжийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм болон олон улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудын үр дүнд үндэслэн өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, ойлгомжтой, найдвартай байдлыг шалган судалгаанд ашигласан. Судалгааны үр дүнгийн тоон үзүүлэлтийн статистик боловсруулалтад SPSS-25.0 программыг ашиглаж $P < 0.05$ үед статистик ач холбогдолтой гэж үзэв.

Үр дүн: Судалгаанд оролцогчдын 339 (90.4%) нь эмэгтэй ба 301 (80.48%) нь эм зүйч, 73 (19.52 %) эм найруулагч мэргэжилтэй байв. Мөн 259 (69.3%) нь II зэрэглэлийн эмийн санд ажилладаг бөгөөд ёс зүйн сургалтад 305 (81.6%) нь хамрагдсан байлаа. Жор баригч нарын өөрийн ёс зүйн мэдлэгийг үнэлсэн байдал өдөрт үйлчилгээ үзүүлдэг үйлчлүүлэгчийн тоонд статистик ач холбогдол бүхий ялгаатай ($p < 0.000$) болох нь тодорхойлогдлоо. (Зураг 1)



Зураг 1. Жор баригчид өөрийн ёс зүйн мэдлэгийг үнэлсэн байдал, (n=374)

Судалгаанд оролцогчдын мэргэжлийн байдал нь ажилласан жил болон насны бүлэгт статистик ач


холбогдол бүхий ялгаатай байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл (мэргэжлээр)

	Үзүүлэлт	Эмзүйч	Эм найруулагч	Рутга
Мэргэжлийн зэрэг	Ахлах	26 (8.6%)	3 (4.1%)	0.47
	Тэргүүлэх	2 (0.7%)	0 (0%)	
	Зөвлөх	0 (0%)	2 (2.7%)	
	Зэрэг байхгүй	273 (90.7%)	68 (93.2%)	
Нас (жилээр)	25-аас доош	105 (34.9%)	16 (21.9%)	0.0001
	26-30	95 (31.6%)	14 (19.2%)	
	31-39	66 (21.9%)	20 (27.4%)	
	40-49	21 (7.0%)	12 (16.4%)	
	50-59	9 (3.0%)	11 (15.1%)	
	60-аас дээш	5 (1.7%)	0 (0%)	
Ажилласан жил	5-аас бага	182 (60.5%)	32 (43.8%)	0.002
	6-10 жил	73 (24.3%)	18 (24.7%)	
	11-15 жил	29 (9.6%)	12 (16.4%)	
	16-20 жил	6 (2.0%)	4 (5.5%)	
	21-25 жил	8 (2.7%)	3 (4.1%)	
	26-аас дээш	3 (1.0%)	4 (5.5%)	
Үйлчлүүлэгчийн тоо	50-аас бага	33 (8.8%)	8 (2.1%)	0.491
	50-100	123 (32.9%)	30 (8%)	
	101-150	67 (17.9%)	23 (6.1%)	
	151-200	35 (9.4%)	6 (1.6%)	
	201-ээс дээш	43 (11.4%)	3 (1.6%)	

Судалгаанд оролцсон жор баригч нарын эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчим, хэм хэмжээний талаарх мэдлэгийн дундаж оноо 2.75 ± 0.59 байсан ба 56.1% нь дунджаас бага оноо, ёс зүйн зарим асуудалд хандах хандлагыг үнэлэхэд 54.5% нь дунджаас бага оноо (дундаж оноо 3.24 ± 0.43), зохистой

дадал тодорхойлоход 48.9% нь дунджаас бага оноо (дадлын дундаж оноо 3.47 ± 0.47) тус тус авсан байв. Дундаж оноог шалгуур үзүүлэлт болгон дунджаас их бол хангалттай, бага бол хангалтгүй гэсэн түвшинд хувааж мэргэжилтэй нь уялдуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаагүй байлаа. (Зураг 2)



Зураг 2. Ёс зүйн мэдлэг, хандлага, дадлын түвшинг мэргэжилтэй уялдуулан судалсан дүн

Жор баригч нарын ёс зүйн мэдлэг нь мэргэжил, нас, нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилласан жил, мэргэжлийн зэрэг, төгссөн сургууль зэрэгт ялгаагүй, харин оролцогчдын өөрийгөө үнэлсэн ёс зүйн мэдлэгийн үнэлгээтэй статистик ач холбогдол бүхий хамааралтай (CL 95%, $p=0.0001$) байлаа.

Ёс зүйн асуудалд хандах хандлагыг

тодорхойлох тохиолдлуудаас үйлчлүүлэгчийн бие даасан байдалд хандах жор баригчийн хандлага эерэг байна. Тухайлбал “Үйлчлүүлэгч жоргүй олгодог эм авах гэхэд тухайн эмийг заавал хэрэглэх шаардлагагүйг ойлгосон ч эмийг олгоно” гэдэгт жор баригчдын 81% нь санал нийлэхгүй гэж хариулсан бөгөөд энэ нь нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилласан жилээс

хамаарч ялгаатай байна ($p=0.017$). Мөн “Эм хэрэглэх арга, хадгалах нөхцөл, зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгч асуусан үед л хэлнэ” гэсэн тохиолдолд 82.6% нь санал нийлэхгүй гэж хариулсан нь насны бүлэг ($p=0.027$) болон мэргэжлийн зэрэг ($p=0.009$) гэсэн хувьсагчидтай статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Харин үйлчлүүлэгчийн нууцлалтай холбоотой ёс зүйн асуудал болох “Оюутан охиных нь худалдаж авсан эмийн талаар ээжид нь мэдэгдэх нь зөв” гэсэн тохиолдолд 90 (24.1%) нь санал нийлнэ, 128 (28.3%) нь дунд зэрэг, 178 (47.6%) санал нийлэхгүй гэж хариулсан бол үйлчлүүлэгч өөрөө хэрэглэдэггүй эмийн талаар асуувал бүх мэдээллийг өгөх тухайд 332 (88.8%) нь санал нийлсэн хариулт өгч сөрөг хандлага үзүүлсэн. Жор баригч нарын хандлагын түвшин нь насны бүлэгтэй статистик ач холбогдол бүхий ($CL\ 95\%, p=0.0001$) хамааралтай байгаа нь тогтоогдлоо.

“Эмийн жорд бичигдсэн оригинал эм байхгүй үед ижил үйлчилгээтэй женерик эм олгохоор бол үйлчлүүлэгчдэд мэдэгддэг үү?” гэсэн асуултад 196 (52.4%) нь тогтмол, 105 (28.1%) нь ихэвчлэн, 62 (16.6%) нь заримдаа, 9 (2.4%) нь хааяа, 2 (0.5%) нь хэзээ ч үгүй гэж хариулсан бол “Үйлчлүүлэгч хэрэглэж байсан антибиотикоо гэртээ мартсанаа тайлбарлаад эмчилгээгээ үргэлжлүүлэхийн тулд антибиотیکیг жоргүйгээр авахыг хүсвэл эмийг олгох уу?” гэдэгт 65 (17.4%) нь хэзээ ч үгүй, 119 (31.8%) нь хааяа, 147 (39.3%) нь заримдаа, 36 (9.6 %) нь ихэвчлэн, 7 (1.9%) нь тогтмол гэж хариулжээ.

Хэлцэмж: Энэхүү судалгаагаар жор баригчийн мэргэжлийн ёс зүйн талаарх мэдлэг, зарим ёс зүйн асуудалд хандах хандлага, дадлыг анх удаа үнэлсэн. Бидний судалгаанд оролцогчдын 81.6% нь ёс зүйн сургалтад хамрагдсан нь Wudneh Simegn (2021) нарын судлаачдын Этиоп улсад 305 эм зүйн мэргэжилтнийг хамруулсан судалгааны үр дүнтэй (82.6%) ойролцоо, Mohamed N (2013) нарын Саудын арабын төв хэсэгт 682 эм зүйчийн дунд явуулсан судалгааны үр дүн (72.3%) болон Saw, P.S (2018) нарын Малайз улсын 37 эм зүйчийг хамруулсан судалгааны үр дүнгээс өндөр байна.⁹⁻¹¹ Эм барих эрхийн зөвшөөрлийг кредит цаг бүрдүүлэх байдлаар сунгахад ёс зүйн сургалтад хамрагдсан байхыг шаарддаг тул сургалтад хамрагдсан жор баригчийн тоо өндөр байх нь гарцаагүй юм. Гэвч жор баригч нарын 56.2% нь мэргэжлийн ёс зүйн мэдлэг хангалтгүй байна. Энэ нь судлаач С.Болормаа (2015) нарын улсын харьяаны байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг оролцуулсан судалгааны үр дүнтэй (58%) ойролцоо, Нигер улсын 300 эм зүйчийг хамруулсан Okoro RN (2022) нарын судалгааны үр дүнгээс (49.4%) өндөр байна.^{12,13}

Харин жор баригч нарын ёс зүйн асуудалд хандах хандлага, дадлыг үнэлэхэд 45.5% нь эерэг хандлага, 51.1% нь зохистой дадалтай байв. Энэ үр дүн нь Ibrahim Albaroodi KA (2024) нарын судлаачдын Ирак улсын 202 эм зүйчийг хамруулсан судалгааны үр дүнтэй (хандлага-42.6 %, дадал- 56 %) ойролцоо, Denise Pasesa (2024) нарын судлаачийн Индонез улсын Суракарта хотын 205 эм зүйчийг оролцуулсан

судалгааны үр дүнгээс (60%) бага байна.^{14,15}

Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэх зарчимд хамаарах “Үйлчлүүлэгч жоргүй олгодог эм авах гэхэд тухайн эмийг заавал хэрэглэх шаардлагагүйг ойлгосон ч эмийг олгоно” гэсэн тохиолдолтой жор баригчдын 81% нь санал нийлэхгүй гэж хариулсан нь Al-Qudah RA (2019) нарын судлаачдын Иордан улсын 704 эм зүйчийг хамруулсан судалгааны үр дүнгээс (62%) өндөр байна. Мөн тус судалгаанд жорд бичигдсэн оригинал эм нь байхгүй тохиолдолд женерик эм олгохдоо үйлчлүүлэгчдэд 86.22% нь мэдэгддэг гэсэн нь бидний судалгааны дүнгээс (80.5%) өндөр байна.¹⁶

Дүгнэлт:

1. Жор баригч нарын мэргэжлийн үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах ёс зүйн тулгуур зарчим, ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдлэг хангалтгүй байна.
2. Зарим ёс зүйн тохиолдлуудад хандах хандлага сөрөг, дадал зохисгүй байна. Иймд эм зүйн мэргэжилтнүүдийн эрүүл мэндийн салбарт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, эм зүйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд боловсрол олгох түвшин болон ажлын байранд явуулах сургалтыг мэргэжилтнүүдийн хэрэгцээнд тулгуурлан эрчимжүүлэх шаардлагатай юм.

Талархал: Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд тусалж дэмжсэн Монголын Эм Зүйн Байгууллагуудын Нэгдсэн “ЭМ” Холбоо ТББ-ын хамт олонд болон судалгаанд оролцсон нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм зүйн мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

Номзүй:

1. DiPietro Mager N, Bright D. Advancing Public Health through Community Pharmacy Practice. *Pharmacy* (Basel). 2023 Mar 15;11(2):56. doi:10.3390/pharmacy11020056. PMID: 36961034; PMCID: PMC10037598
2. Sawada, Y., Takehira, R. and Yamamura, S. (2015) Japanese Community Pharmacists' Barriers to Conducting or Participating in Practice Research. *Pharmacology & Pharmacy*, 6, 421-427. doi:10.4236/pp.2015.69043
3. Raimundo R, Cavaco A. “I Solemnly Swear”: A Comparative Study of Codes of Professional Ethics amongst Pharmacists from Culturally Diverse European Countries. *Pharmacy*. 2024; 12(5):143. <https://doi.org/10.3390/pharmacy12050143>
4. World Health Organization. Regional Office for Europe. (2019). *The legal and regulatory framework for community pharmacies in the WHO European Region*. World Health Organization. Regional Office for Europe. <https://iris.who.int/handle/10665/326394>. License: CC BY-NC-SA 3.0 IGO
5. Rasool Esmalipour, Bagher Larijani, Neda Mehrdad, Abbas Ebad, Pooneh Salari, The ethical challenges in pharmacy practice in community Pharmacies: A qualitative study, *Saudi Pharmaceutical Journal*, Volume 29, Issue 12, 2021, Pages 1441-1448, ISSN 1319-0164, <https://doi.org/10.1016/j.jsps.2021.11.003>.
6. Brian OO, Henry NC. Community pharmacists and health promotion activities in the 21st century; maximizing the expanded roles for universal health coverage and population health optimization. *MOJ Public Health*. 2017;6(3):354–358. DOI: 10.15406/mojph.2017.06.00174
7. Ayenew, W., Seid, A.M., Kasahun, A.E. et al. Assessment of community pharmacy professionals' willingness, involvement, beliefs, and barriers to offer health promotion services: a cross-sectional study. *BMC Health Serv Res* 22, 1539 (2022). <https://doi.org/10.1186/s12913-022-08888-8>

- org/10.1186/s12913-022-08944-w
8. Jadranka Vukovic. *Perceptions and attitudes of community pharmacists toward professional ethics and ethical dilemmas in the workplace*. *Res Social Adm Pharm* 2018 May;14(5):441-450. Doi: 10.1016/j.sapharm.2017.05.010
 9. Wudneh Simegn, Berhanemeskel Weldegerima, Alem Endeshaw, Gashaw Sisay, Abdulwase Mohammed, Dawit Wondimsigegn. *Assessment of Community Pharmacy Professionals' Attitude and Perception Towards Ethical Issues in Amhara Region, Ethiopi*. Dove press.2 october 2021 Volume 2021:14 Pages 4127-4139 doi:10.2147/RMHP.S328328
 10. Mohamed N. Al-Arifi, *Community pharmacist perception and attitude toward ethical issues at community pharmacy setting in central Saudi Arabia*, *Saudi Pharmaceutical Journal*, Volume 22, Issue 4, 2014, Pages 315-325, ISSN 1319-0164, <https://doi.org/10.1016/j.jsps.2013.08.003>
 11. Saw, P.S., Chuah, L.H. & Lee, S.W.H. *A practical approach toward teaching ethics to community pharmacists*. *Int J Clin Pharm* 40, 1131–1136 (2018). <https://doi.org/10.1007/s11096-018-0707-8>
 12. Болормаа С., Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороодын үйл ажиллагаа, бүтцийн өнөөгийн байдал. Нийгмийн эрүүл мэндийн ухаанаар магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль; 2015 он
 13. Okoro RN, Hedima EW, Abdullateef S, Aguiyi-Ikeanyi CN, Muddenda S. *Ethics of Pharmacy Practice: Ethical Principles Knowledge and Perceived Ethical Practices of Community and Hospital Pharmacists in Nigeria*. *Ind J Pharm Pract [Internet]*. 2022 Oct 9;15(4):308–14. Available from: <http://dx.doi.org/10.5530/ijopp.15.4.55>
 14. Ibrahim Albaroodi KA. *Pharmacist knowledge, attitude, and practice regarding pharmacy code of practice and ethics in Iraq*. *J Public Health Res*. 2024 Oct 13;13(4): 22799036241290271. Doi:10.1177/22799036241290271. PMID: 39403624; PMCID: PMC11472382
 16. Denise Pasesa, R., & Da'i, M. (2024). *Knowledge and Application of Pharmacist Ethical Practices in Surakarta City*. *Journal La Medihealtico*, 5(2), 251-262. <https://doi.org/10.37899/journal-lamedihealtico.v5i2.1097>
 17. Al-Qudah RA, Tuza O, Tawfik H, Chaar B, Basheti IA. *Community pharmacy ethical practice in Jordan: assessing attitude, needs and barriers*. *Pharm Pract (Granada)*. 2019 Jan-Mar;17(1):1386. doi:10.18549/PharmPract.2019.1.1386. Epub 2019 Mar 17. PMID: 31015876; PMCID: PMC6463417.

Evaluating the professional ethical knowledge, attitudes, and practices of pharmacists

Udval B¹, Myagmarsuren B¹, Munkhbat S¹

¹Department of Clinical pharmacy and pharmaceutical management, School of Pharmacy, MNUMS
E-mail: Udva5555@gmail.com, Tel: +976-88074187

Background: Medical experts in pharmacies are the most accessible health professionals and play a key role in primary health care. They must strike a balance between their autonomy, the objectives of the company, and professional standards, while facing a lot of ethical dilemmas. This phenomenon can impact the quality of pharmaceutical care, as highlighted in several studies. Numerous studies have been carried out internationally to explore the medical ethics knowledge of pharmacists working in community pharmacies, their attitudes towards emerging ethical issues, and identification of their common problems. However, research in this area is scarce in Mongolia, which serves as the basis for conducting this study.

Aim: Assessing the knowledge, attitudes, and practices of pharmacists regarding professional ethics in community pharmacies in Ulaanbaatar city.

Materials and Methods: This study was conducted using an analytical cross-sectional study design and included 374 pharmacists who had been working in community pharmacies in Ulaanbaatar for more than three months, had a valid professional license, and consented to participate in the study between March and September 2024 (ethical approval number 2024/3-01). To determine the degree of knowledge, attitude, and practice, a questionnaire including 39 closed questions and 4 groups was used to gather survey data. For statistical analysis, SPSS-25 software was utilized.

Results: Of those who took part, 301 (80.48%) were pharmacists, 73 (19.52%) were pharmacy technicians, and 339 (90.4%) were women. Additionally, 259 (69.3%) work in secondary pharmacies, and 305 (81.6%) have received ethics training. The study shows that 56.1% of pharmacists had insufficient knowledge of professional ethics, 54.5% had poor attitudes towards ethical issues, and 48.9% had inappropriate practices. When analyzed in relation to their profession, the ethical knowledge of pharmacists did not differ by profession, age, years of experience in community pharmacies, professional degree, and university graduated, but it was statistically significantly correlated with the participants' self-assessed ethical knowledge (CL 95%, p=0.0001).

Conclusions:

1. The knowledge of professional ethical principles and standards is insufficient among pharmacists.
2. While handling emerging ethical issues, they have a negative attitudes and inappropriate practices. Consequently, it is compulsory to intensify training on the ethical code of conduct for medical experts s based on the needs of pharmaceutical professionals.

Keywords: Ethics of pharmaceutical professional, Community pharmacy, Pharmacist, Health professional